

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС АВЛИГЫН ЭСРЭГ
2014 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2014.11.14

д/д	Хэрэгжүүлэх ажил	Биелэлт
1	Хууль, бусад шийдвэрийн төслүүдийн талаар иргэдээс санал хүлээж авах механизм /цахим хуудсаар, санал асуулга г.м/-ыг бүрдүүлэх	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг ХҮХ-тэй хамтран худалдаа, үйлчилгээ явуулж байгаа байгууллагуудын дунд, иргэдийн дунд, төрийн албан хаагчдын дунд гэсэн 3 үе шаттайгаар зохион байгуулсан.
2	Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал, шторк г.м/	2014 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр Авлигатай тэмцэх газартай хамтран Авлигын эсрэг Сүхбаатарчууд бид хамтдаа сэдэвт эссэ болон илтгэлийн тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадуудын төрийн албан хаагчид оролцсон байна. Илтгэлийг 2 үе шаттайгаар зохион байгуулж, эссэ бичлэг, илтгэлийн тэмцээн тус бүрээс эхний 3 байрыг шалгаруулж Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан.
3	Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллагад түгээн ажиллах	Авилгатай тэмцэх газраас сурталчилгааны материал ирүүлээгүй.
4	Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсанд байршуулах, иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах, харилцан санал солилцох боломжийг бүрдүүлэх, саналыг тусгах	Хэм хэмжээ тогтоосон захиргааны акт ЗДТГ-аас гардаггүй бөгөөд Засаг даргын А захирамжийг байгууллагын цахим хуудасны тогтоол шийдвэр буланд байршуулж, нийтэд ил тод мэдээлж байгаа болно.
5	Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг хангах	2014 онд худалдаа, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд явуулах хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, холбогдох хэлтэс, алба, агентлагуудтай хамтран гүйцэтгэлийг ханган ажилласан.Хяналт, шалгалтын ажил төлөвлөгөөний дагуу бүрэн хийгдсэн.
6	Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлэх	Дүүргийн хэвлэл, мэдээллийн албаар дамжуулан дүүргийн sbd.ub.gov.mn цахим хуудаст байрлуулсан. Мөн хэлтсийн мэдээллийн самбар дээр байрлуулсан.
7	Хяналт шалгалтын мөрөөр арга хэмжээ авах /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах/	Хяналт, шалгалтын илтгэх хуудсыг тухай бүр нь бичиж, дүүргийн удирдлагуудад танилцуулан, холбогдох хэлтэс, албадуудад хүргүүлсэн.

8	2014 оны жилийн төсөв 2013 оны төсвийн гүйцэтгэл 2015 оны төсвийн төсөл/-ийг цахим хуудсанд байршуулах	2013 оны тодотгосон төсөв, гүйцэтгэл болон 2014 оны батлагдсан төсвийн талаарх мэдээлэл, 2015-2017 оны төсвийн төслийг цахим хуудас болон самбарт байршуулсан.
9	Жилийн эцсийн санхүүгийн тайлан /4 дүгээр сарын 1-ний дотор/-г цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	Орон нутгийн төсвийн 2013 оны санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан 2014 оны хагас жилийн нэгтгэсэн тайлангуудыг цахим хуудас болон самбарт байршуулсан.
10	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /4 дүгээр сарын 1-ний дотор/-ийг бүрэн эхээр нь цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтыг бүрэн эхээр нь цахим хуудсан болон мэдээллийн самбарт байршуулсан.
11	Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл /өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт/-ийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	2014 оны төсвийн тодотголийг 2014.09.10 нд хийсэн. 2014 оны 10 сард цахим хуудсанд байршуулсан.
12	Төсвийн орлого бүрдүүлэлтийн талаарх мэдээлэл /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/-ийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	Төсвийн орлогын мэдээ, төсвийн гүйцэтгэлийн зардлын мэдээг сар бүр цахим хуудсанд байршуулж байна.
13	Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий албан хаагчийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	Нууцын зэрэглэлтэй тул мэдээлэл өгөх боломжгүй гэсэн хариуг Нийгмийн даатгалын хэлтсээс өгсөн.
14	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	Байгууллагын www.sbd.ub.gov.mn цахим хуудасны дотоод мэдээлэл буланд Төсөл хөтөлбөрүүд цэсэнд байршуулсан байгаа.
15	Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалт, түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	Дүүргийн sbd.ub.gov.mn цахим хуудасны төрийн үйлчилгээ гэсэн цонхны зөвшөөрөл, тодорхойлолт гэсэн хэсэгт болон хэлтсийн мэдээллийн самбарт байрлуулсан.
16	Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуус-гавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	Дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн жагсаалт мөн дүүргийн Засаг даргын захирамжаар тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгосон худалдаа, үйлчилгээний газруудын нэрс болон захирамжуудыг тухай бүр нь дүүргийн цахим хуудаст байрлуулсан.

17	Хуулиар хориглоогүй бүртгэлийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах /хууль тогтоомжид зааснаар бүртгэл хийхээр тусгасан бүртгэлүүд/	Дүүргийн худалдаа, үйлчилгээний байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэж, судалгаа гарган Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст хүргүүлж, мэдээлэл авахыг хүссэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд мэдээллийг өгч байна. www.sbd.ub.gov.mn цахим хуудасны нээлттэй булан Төрийн үйлчилгээ цэсд байгаа
18	Ажлын байрны сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулах	Засаг даргын Тамгын газарт гарсан сул орон тооны мэдээллийг www.sbd.ub.gov.mn цахим хуудасны шинэ мэдээ цэсд Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд нөөцөд бүртгэлтэй иргэдийг ярилцлаганд урьж байна гарчигтайгаар нийтлэгдсэн.
19	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	Дүүргийн Засаг даргын 2014.03.12-ны өдрийн А/96 дугаар захирамжаар “Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, сургалт, нийгмийн баталгааг хангах талаар 2014-2016 онд хэрэгжүүлэх хөтөлбөр”-ийг албан хаагчдаас авсан судалгаа, санал, хэрэгцээ шаардлагыг үндэслэн боловсруулан батлуулж, байгууллагын цахим хуудасны тогтоол, шийдвэр булангийн захирамж цэсэнд байршуулсан.
20	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нээлттэй байдлыг хангах	Байгууллагын удирдах албан тушаалтнуудын талаарх мэдээллийг www.sbd.ub.gov.mn цахим хуудасны Засаг дарга буланд байршуулсан.
21	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нээлттэй байдлыг хангах	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу үнэлж дүгнэдэг. Албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлт болон үнэлж дүгнэсэн байдал үнэн зөв бодитой эсэхэд Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтнээр төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд бүрэн тусгагдсан эсэх, цаг үеийн ажилд оролцсон байдал, өгөгдсөн үүрэг даалгавар цаг хугацаандаа өгсөн байдал зэргийн бүртгэлийг гаргуулан, Хяналт шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтнээр хяналт шинжилгээ хийлгэн, гарсан дүнг харгалзан дараагийн шатны даргын үнэлгээ тавигдах журмаар үнэлж байна.
22	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах	Дүүргийн 2014 онд бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2014 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн Өдрийн сонин, мөн дүүргийн sbd.ub.gov.mn сайтад байршуулан нийтэд мэдээлсэн.
23	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулах	Дүүргийн sbd.ub.gov.mn сайтад Тендерийн жишиг баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах хууль тогтоомж, журам зааврыг байршуулсан. Мөн дүүргийн Мэдээллийн самбарт тендерийн урилгыг тендер зарлагдаж буй тухай бүрт, худалдан авах ажиллагааны

		<p>мэдээллийг сар, улирал бүрт тогтмол байршуулж хэвшлээ.</p> <p>Засгийн газрын Худалдан авах ажиллагааны газар болон Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар хамтран эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн хүрээнд төрийн худалдан авах ажиллагааны бодлогыг сурталчлах “Ил тод худалдан авалт” нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, энэ үеэр 2013-2014 ондуудад тус дүүрэгт төсвийн хөрөнгөөр зохион байгуулсан хөрөнгө оруулалтын ажлын явц, үр дүнгийн талаар болон худалдан авах ажиллагаанд төрөөс хэрэгжүүлж буй бодлогыг иргэд, олон нийтэд танилцуулав. Мөн дүүргийн хэмжээнд хэрэгжих Олон нийтийн оролцоотой худалдан авалтын ажлуудыг мэдээлж, дүүрэг хороондоо хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, тендэрт оролцогчдод зориулсан зөвлөмж гарын авлагыг тараан ажиллаа.</p> <p>Нийслэлийн 375 жилийн ойг тохиолдуулан Сүхбаатар дүүргийн “Дүүргийн хөгжилд-Иргэний оролцоо” сэдэвт иргэдийн баяр, нээлттэй өдөрлөгийг Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд 2014.10.25-ны өдөр зохион байгуулсны хүрээнд Сүхбаатар дүүргийн худалдан авах ажиллагааны алба нь 2014 онд тус дүүрэгт төсвийн хөрөнгөөр зохион байгуулсан хөрөнгө оруулалтын ажлын явц, үр дүнгийн талаар иргэд, олон нийтэд танилцууллаа. Мөн дүүрэгт энэ жил хэрэгжиж буй Олон нийтийн оролцоотой худалдан авалтын ажлууд болон худалдан авах ажиллагаанд төрөөс хэрэгжүүлж буй бодлого, дүүрэг хороондоо хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлын талаар 200 орчим иргэн болон аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэл хийж, сонирхсон асуултуудад хариулт өгч, тендэрт оролцогчдод өгөх зөвлөмж, олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны зөвлөмж, төсвийн хөрөнгөөр зохион байгуулж байгаа хөрөнгө оруулалтын ажлын үр дүнгийн танилцуулга зэргийг хэвлүүлэн нийт 200 гаруй хэвлэмэл материал, гарын авлага түгээж, албаны үйл ажиллагааг сурталчлан ажиллав.</p>
24	Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлах	Өдрийн сонин, Нийслэл таймс зэрэг өдөр тутмын сонингуудтай гэрээ байгуулсны хүрээнд тендерийн урилгыг хэвлэн нийтлүүлэхээс гадна Сангийн яамны e-procurement.gov.mn, meps.gov.mn, Ulaanbaatar.mn, sbd.ub.gov.mn сайтуудад байршуулсан болно. Мөн Нээлттэй Сүхбаатар дүүрэг page хуудас болон Oloo.mn сайтууд байршуулан ажиллаж байна.

25	Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийн талаарх нээлттэй байдлыг хангах	Тендерт оролцохыг сонирхогч, эрх бүхий аж ахуйн нэгж байгууллагуудад тендерийн баримт бичигт тавигдах шалгуур үзүүлэлтийг нээлттэй болгох үүднээс 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн "Өдрийн сонин" "Нийслэл таймс" сонингуудад болон sbd.ub.gov.mn сайтад хамтран ажиллах урилгыг хүргүүлсэн. 2014 онд төсвийн хөрөнгөөр дүүргийн бүтээн байгуулалт, тохижилт, засвар үйлчилгээний чиглэлээр хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон 529 ахуйн нэгж байгууллагын хамтран ажиллах саналыг хүлээн авч шалгуур үзүүлэлтэнд нийцсэн эрх бүхий байгууллагуудыг сонгон авч тендерийн урилга хүргэн хамтран ажиллаж байна..
26	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийн нээлттэй байдлыг хангах	Сар бүрийн худалдан авах ажиллагааны тайланг дүүргийн sbd.ub.gov.mn сайтад байршуулдаг.
27	Тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар танилцуулах	Тендерт оролцсон компаниудад мэдэгдлийг хүргүүлж, шалгараагүй шалтгаан хуулийн үндэслэлийг танилцуулж, цаашид тендерт оролцоход анхаарах зүйлүүдийн зааварчилгааг өгч ажиллаж байна.
28	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсанд мэдээлэх	sbd.ub.gov.mn сайтад байршуулсан нийтэд мэдээллэн ажиллаж байна.
29	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэх	Тендер шалгаруулалтын явцад илэрсэн зөрчил байхгүй болно.
30	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнгийн талаарх нээлттэй байдлыг хангах	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас 2014 оны 4-5 дугаар сард дүүргийн ЗДТГ-ын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийсэн бөгөөд тус шалгалтаар худалдан авах ажиллагаатай холбогдсон зөрчил илэрч, акт тавигдаагүй болно.
31	<i>Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах</i>	Үнэлгээний хороонд дүүргийн ИТХ-аас томилогдсон иргэнийг Засаг даргын захирамжаар тухай бүр оруулж ажиллаж байгаагаас гадна тухайн ажил үйлчилгээ, нарийн мэргэжлийн онцлогоос шалтгаалан эрүүл мэндийн тоног төхөөрөмж худалдан авах, мэдээллийн технологи худалдан авч суурилуулах авто замын засвар шинэчлэлийн ажлуудад мэргэжлийн байгууллагатай зөвшилцөж холбогдох мэрэгжилтийг үнэлгээний хороонд ажиллуулж байна.
32	Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлэх	Дүүргийн Засаг даргын 2013.01.04-ний өдрийн 04 дүгээр захирамжаар Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталсантай холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж бүтэц, орон тооны дагуу бүх ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулсан. Уг

		батлагдсан ажлын байрны тодорхойлолтыг албан хаагч тус бүрт 1 хувийг өгч мөрдүүлэн ажиллаж байна.
33	Албан хаагч нэг бүрийн хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах	Байгууллагын цахим хуудасны Тамгын газар буланд хэлтэс тус бүрийн зорилго, зорилт, чиг үүрэг, албан хаагчдын зураг, албан тушаал, ерөөний дугаар, утасны дугаар, и-майл хаягийг байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна.
34	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллах	2014 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дүүргийн Иргэдийн баяраар Авлигын эсрэг хууль, шилэн дансны тухай хуулийн гарын авлага бэлтгэн аж ахуйн нэгж иргэдэд тараасан.
35	Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хамтын ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх	Энэ төрлийн судалгаа одоогоор хийгдээгүй байна.
36	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдах	Авлигатай тэмцэх газартай хамтран 2014 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Засаг даргын Тамгын газрын болон хороодын төрийн албан хаагчдыг хамарсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар сургалт зохион байгууллаа.
37	Хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтыг хангах	Албан хаагчдын хувийн хэрэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хадгалах зориулалтаар тусгай төмөр сейфээр хангаж өгсөн.
38	Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м/-ийг бүрдүүлэх	Байгууллагын цахим хуудасны санал хүсэлт булан болон албаны 70070112 дугаарын утсаар мэдээллийг авч байна.Одоогийн байдлаар ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл ирээгүй байна.
39	Ашиг сонирхлын зөрчлийн талаарх бүртгэл хөтлөх, зөрчлийг хянан шийдвэрлэх	Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл ирээгүй байна.
40	Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулах	Авлигатай тэмцэх газартай хамтран 2014 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Засаг даргын Тамгын газрын болон хороодын төрийн албан хаагчдыг хамарсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар зохион байгуулсан сургалтаар давхар ажил эрхлэлтийн талаарх мэдээллийг өгсөн.

41	Албан тушаалтанд давхар ажил эрхлэх зөвшөөрлийг олгох	Давхар ажил эрхлэж байгаа албан хаагч байхгүй.
42	Давхар ажил эрхлэхтэй хол-богдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журмын биелэлтийг хангах	Давхар ажил эрхлэж байгаа албан хаагч байхгүй.
43	Эрх бүхий албан тушаалтнаас гаргаж буй шийдвэрийг ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлэх /цахим хуудас, мэдээллийн самбар/	Иргэд болон албан тушаалтнууд, судалгааны ажилтнуудын мэдээлэл авах эрхийг хангах үүднээс дүүргийн www.sbd.gov.mn сайтад засаг даргын 2013 оноос хойш захирамжийг байршуулан ажиллаж байна
44	Эрх бүхий албан тушаалтнаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад олон нийтийг хамарсан шийдвэр /тушаал, захирамж/-ийн нээлттэй байдлыг хангах	Дүүргийн Засаг даргын 2013 оноос хойш захирамжийг www.sbd.gov.mn сайтын Захирамж цэсэнд байршуулан ажиллаж байна.
45	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын нээлттэй байдлыг хангах	Нийслэл болон дүүргүүдийн хэм хэмжээ тогтоосон актын нэгдсэн лавлахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын www.ublegal.mn сайтад төвлөрүүлж байгаа бөгөөд тус дүүргээс гарч буй актуудыг мөн байршуулсан болно.
46	Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах	Дүүргийн sbd.ub.gov.mn цахим хуудасны төрийн үйлчилгээ гэсэн цонхны зөвшөөрөл, тодорхойлолт гэсэн хэсэгт болон хэлтсийн мэдээллийн самбарт байрлуулсан.
47	Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)	Дүүргийн sbd.ub.gov.mn цахим хуудсаны санал хүсэлт булан, санал хүсэлтийн хайрцаг, Ёс зүйн хорооны мэдээллийн самбарын санал хүсэлтийн хайрцаг, 70070116 дугаарын утсаар иргэд өргөдөл, гомдол, хүсэлт мэдээлэл зэргийг ирүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.
48	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах	Иргэдийн эрэлт хүсэлт хариуцсан мэргэжилтний овог нэр, албан тушаал, харилцах утас, мэйл хаяг зэргийг цахим хуудас болон мэдээллийн самбарт ил тод байршуулсан. Дүүргийн Засаг дарга болон орлогч дарга нарын иргэдтэй уулзах хуваарийг дүүргийн Засаг даргын 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/19 дүгээр захирамжаар баталсан бөгөөд цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан хуваарийн дагуу иргэдийг хүлээн авч уулзаж байна.
49	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг сар бүр гарган нэгтгэж, цахим хуудсаар мэдээлдэг.
50	Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлэх	Албан хаагчдын болон байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ил тод мэдээлэн ажиллаж байгаа бөгөөд хүнд суртал, чирэгдэл, ашиг сонирхлын зөрчлийн талаарх
51	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч	

	хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулах/	иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл байхгүй байна.
52	Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг АТГ-т мэдээлэх	Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудал гараагүй байна.
53	АТГ-аас хийсэн шалгалтын явцад зөрчил илэрсэн тохиолдолд мэдээлээгүй бу-руутай этгээдэд холбогдох хариуцлага хүлээлгэх	Мэдээлэл ирээгүй.
54	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн бие-лэлтийг хангах	Зөвлөмж ирээгүй.
55	АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөх-цөлийг арилгуулахаар хүр-гүүлсэн мэдэгдлийн биелэлтийг хангах	Мэдэгдэл ирээгүй.
56	АТГ-аас зөрчил арилгуулах, хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлтийг хангах	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2014 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ц.Алтансувдад хариуцлага тооцуулах тухай 03/7179 дүгээр албан бичгийн дагуу Ц.Алтансувдад Засаг даргын Тамгын газрын 2014 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн Б/223 дугаар тушаалаар сарын үндсэн цалинг 1 сарын хугацаатай 30 хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан. Уг тушаалын хуулбарыг Засаг даргын Тамгын газрын 2014 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 3/3264 дүгээр албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.
57	АТГ-аас авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох	Тус байгууллага нь нийтэд дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг гаргадаггүй болно.
58	АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ын биелэлтийг хангах	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2014 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ц.Алтансувдад хариуцлага тооцуулах тухай 03/7179 дүгээр албан бичгийн дагуу Ц.Алтансувдад Засаг даргын Тамгын газрын 2014 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн Б/223 дугаар тушаалаар сарын үндсэн цалинг 1 сарын хугацаатай 30 хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан бөгөөд уг шийдвэрийг Ц.Алтансувд нь хүлээн зөвшөөрөөгүй. Иймд дээд шатны удирдах албан тушаалтанд гомдлоо гаргаж, өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох

		этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээ аваагүй болно.
59	Албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ зохион байгуулах	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, нэгжүүдийн төрийн алба хаагчдын Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээлэлийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиудтай холбоотой эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх, бататгах, авлигаас ангид байх, түүнээс урьдчилан сэргийлэх, алба хаагчдын илтгэх, үйл баримтыг бичгээр илэрхийлэх, багаар ажиллах ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Сүхбаатарчууд бид авлигын эсрэг хамтдаа” сэдэвт эссэ бичлэгийн болон илтгэлийн тэмцээнийг Авлигатай тэмцэх газартай хамтран 2014 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс 11 дүгээр сарын 11-ний өдрийн хооронд зохион байгууллаа. Нийт 22 хэлтэс, нэгжүүдээс эссэ бичлэгийн тэмцээнд 26 албан хаагч, илтгэлийн тэмцээнд 12 албан хаагч оролцож, тэмцээн тус бүрээс эхний 3 байрыг шалгаруулан Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа. Уг тэмцээнд нийттэй 2.098.000 төгрөг зарцуулсан байна.

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Д.БААСАНБАТ

НЭГТГЭСЭН: ХҮНИЙ НӨӨЦ, ТӨРИЙН
АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.ОЧМАА